

СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь тайлант хугацаанд хийсэн ажлын тайлангаа хүргүүлж байна.

“Алсын хараа-2050” зорилт 5.3, 7.4, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, 7.4, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд ажлаа төлөвлөн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын дагуу албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм журмыг чанд баримтлан иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэн ажиллаж байна.

Хууль зүй дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 2.5.3.8 хэсэгт заасны дагуу хэлтсийн албан хаагчдыг мэдээ мэдээллээр тогтмол хангах үүднээс тухай бүр дээд газрын тушаал, шийдвэр, даргын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгавар, цаг үеийн шуурхай хурлын үүрэг даалгаварыг танилцуулан удирдлага арга зүйгээр хангаж, 10 удаа шуурхай хурал зохион байгуулж, биелэлтийг гарган тайлагнаж ажилласан.

“ХАСХОМ” мэдүүлэх үүрэгтэй 25 албан хаагч хуулийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлж гарын үсгийн баталгаажуулж авсан.

Ажилтан албан хаагчдыг мэдээ мэдээллээр тогтмол хангах Төрийн албаны тухай хууль, “Байгууллагын үйлчилгээний стандарт”, дотоод журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах, дээд газрын тушаал, шийдвэр, даргын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгавар, цаг үеийн шинжтэй үүрэг даалгавар, зөвлөмжийг хэлтсийн цахим хуудас болон шуурхай болон өргөтгөсөн хурлаар танилцуулж үүрэгжүүлж ажилласан.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настан, жирэмсэн эхчүүдийг дараалал харгалзахгүй үйлчилж, үйлчилгээний цонх болон мэдээллийн самбарт дараалалгүй үйлчлэх тэмдэг байршуулан, бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.

Иргэн, хуулийн этгээд нь улсын бүртгэлтэй холбоотой лавлагаа, мэдээлэлийг e-mongolia сайт болон ТҮЦ машин, улсын бүртгэлийн байгууллагын цахим машинаас авч үнэ төлбөргүй улсын бүртгэлийн лавлагааг авч байна.



ХОЁР. УБЕГ, НУБГ-ЫН УДИРДЛАГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР, ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Тайлангийн хугацаанд дараах шуурхайн үүрэг даалгавар ирсэнийг цаг тухай бүрт нь нийт албан хаагч нарт биечлэн болон цахим хуудсаар танилцуулан, биелэлтийг гаргаж хүргүүлээ. Үүнд:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 01 дүгээр сарын 10-ний 6/278 тоот дугаартай эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой чиглэл;

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 01 дүгээр сарын 10-ний 3/311 тоот дугаартай “Мэдэгдэл хүргүүлэх тухай”;

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний 4/363 тоот дугаартай “Гадаад паспортын талаар авах зарим арга хэмжээний тухай” чиглэл;

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний 5/334 тоот дугаартай хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой чиглэл;

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны 1/602 тоот дугаартай хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой чиглэл;

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 02 дугаар сарын 28-ны 1/1774 тоот дугаартай “Чиглэл өгөх тухай”;

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 03 дугаар сарын 03-ны 1/1895 тоот дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай”;

Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2023 оны 03 дугаар сарын 17-ны ХЭГ/595 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай”;

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний Улсын бүртгэлийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны 3/3164 тоот дугаартай “Гадаад паспортын бүртгэл хөтлөх” тухай чиглэл;

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн /№8/ удирдах ажилтны шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаварын биелэлт болон гадаад паспортын бүртгэлтэй холбоотой өгсөн үүрэг даалгаварын илтгэх хуудас;

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 04 дүгээр сарын 13-ны 1/2388 тоот дугаартай 2023 оны Улсын бүртгэлийн байгууллагын эрсдэлийг тодорхойлох тухай чиглэл;

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны А/829 тоот дугаартай “Иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох тухай” тушаал;

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 04 дүгээр сарын 13-ны 5/3367 тоот дугаартай “Чиглэл, зөвлөмж хүргүүлэх тухай” чиглэл;

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны 6/3684 тоот дугаартай “Үүрэг, чиглэл хүргүүлэх тухай”;

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 04 дүгээр сарын 24-ний 3/3791 тоот дугаартай Иргэний улсын бүртгэлийн талаар “Чиглэл хүргүүлэх тухай”;

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны 3/3691 тоот дугаартай “Мэдэгдэл хүргүүлэх тухай” чиглэлүүдийг нийт албан хаагч нарт танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Албан хаагчдын “Үйлчилгээний стандарт”-ын хэрэгжилтийг дүгнэх маягтаар хэлтсийн үнэлгээ 98 хувиар үнэлэгдсэн.

Тайлант хугацаанд үйлчилгээний танхимаар үйлчилгээ авахаар ирсэн иргэдээс тухайн үйлчилгээнд өгсөн харилцагчдын үнэлгээний судалгааг авсан.

Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгсөн харилцагчдын дундаж үнэлгээ 55% маш сайн, 30% сайн, 15% дунд гэж үнэлсэн.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1. Албан хэрэг хөтлөлт, шийдвэрлэлтийн талаар:

Албан хэрэг хөтлөлтөд онцгой анхааран, “eDOC” системийн ашиглалтыг сайжруулан, ирсэн явсан бичгүүдийг хууль журамд заасны дагуу шийдвэрлэн ажиллаж байна. Тайлангийн хугацаанд тус хэлтэст ирсэн бичиг-384, үүнээс хариутай-123, хариугүй-261, явсан-257 бичиг

бүртгэгдсэн байх ба нийт-641 албан бичиг EDOC программд оруулан хугацаандаа шийдвэрлэлээ.

Албан бичгийн хугацаа шийдвэрлэлт хуулийн хугацаандаа хийгдсэн ба хугацаа сунгуулсан, хугацаа хоцроосон, хэтэрсэн зөрчилтэй албан бичиг байхгүй.

Иргэд, хуулийн этгээдээс нийт 1 талархал, 1 гомдол, 5 хүсэлт, 5 өргөдөл ирснийг 3-7 хоногийн дотор шийдвэрлэж иргэнд хариуг өгсөн.

Тус хэлтэс нь албан хэрэг хөтлөлтийн "Edoc", ERP системийг албан хэрэг хөтлөлтөнд хэрэглэж, тоон гарын үсгийг ашиглан албан бичгийг илгээж байна.

3.2. Санхүү, үнэт цаасны тайлангийн талаар:

Тайлант хугацаанд санхүүгийн тайлангаар иргэний бүртгэлээр 27.565.000 төгрөг, гадаад паспортын бүртгэлээр тэмдэгтийн хураамж 9410000 төгрөг, үйлчилгээний хураамж 40972500 төгрөг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний хураамж 12466968 төгрөг, тэмдэгтийн хураамж 11624200, татвар 116242000 төгрөг, газар өмчлөх, эзэмших, ашиглах үйлчилгээний хураамж 6124066, татварын орлого 14424000 төгрөгийг дансанд төвлөрүүлээ.

Төсвийн гүйцэтгэлийн болон нэмэлт санхүүжилтийн мэдээг сар бүрийн гүйцэтгэл зардлаар дараа сарын 2-ны дотор УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэст өглөг авлагын дэлгэрэнгүй мэдээтэй хамт тайлагнадаг.

Тус хэлтэс нь 2023 оны эхний 6 сарын байдлаар Улсын төсвөөс 219,4 сая төгрөгийн санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн дансаар 4,4 сая төгрөг нийт 223,8 сая төгрөгийн санхүүжилтээр бүртгэлийн үйл ажиллагааг явуулсан байна. Нэмэлт санхүүжилтээр орж ирсэн 4,4 сая төгрөг нь Уулбаян сумын нөхөн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах, Итгэмжлэгдсэн ажилтны томиллолт, цалин, нэрийн жагсаалт хэвлэх, хэсгийн хороонд хүргэх зардал, тоног төхөөрөмж хотоос авах, хүргэх зардал, гэх мэт зардлуудаар гарах. Үлдэгдэл 4,4 сая төгрөг зардал гараагүй болно. 219,4 сая төгрөгийн санхүүжилтээр: Албан хаагчдын цалинд 164,3 сая, ажил олгогчоос төлөх НДШ-д 36,5 сая, тогтмол зардалд 6,4 сая, хангамж, бараа материалын зардалд 5,3 сая, эд хогшил худалдан авах зардалд 1,1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ зардалд 4,1 сая бараа үйлчилгээний бусад зардал зарцуулалтгүй /80802/ буюу ажил олгогчоос олгох тэтгэмжид 0,6 сая төгрөг нийт 218,3 сая төгрөгийг зарцуулж 1,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2023 онд тус хэлтэс нь улсын төсөвт 110,0 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажиллахаас эхний байдлаар 50,3 сая төгрөгийг төвлөрүүлж ажилласан. Хэлтсийн улсын бүртгэгч нарын орлогын тайланг сар сараар нь авч нэгтгэсэн. Үнэт цаасны тайланг сар бүр бүртгэгч тус бүрээр авч нэгтгэн сар бүрийн 05-ны дотор УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлсэн.

Байгууллагад төлөх өглөг НДХэлтэст эхний 5-р сарын байдлаар 9 сая төгрөгийн өглөгтэй учир нь төрийн албан хаагчийн орон нутагт ажилласаны нэмэгдэл олгох, зэрэг дэвийн нэмэгдэл олгосонтой холбогдуулан өглөгтэй байна.

Сар бүрийн 05-ны дотор хэлтсийн албан хаагчдын НДШимтгэл төлөлтийн тайланг шимтгэл төлөлтийн сайтад шивж хуулийн хугацаа хоцорсон мэдээ тайлан байхгүй болно.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж сар бүр оруулах зохих мэдээлэлийг тогтмол оруулж хэвшсэн. 2023 ондоо 74 мэдээлэл байршуулж хоцорсон болон хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй оруулвал зохих бүх мэдээлэлээ хуулийн хугацаанд бүрэн байршуулсан болно.

2023 онд УБХэлтэс нь шилэн дансны мэдээлэлийн сайтад 175 мэдээлэл оруулах бөгөөд 74 мэдээлэлийг бүрэн байршуулан ажилласан.

3.3 Улсын бүртгэлийн хэлтэс нь Иргэний улсын бүртгэлийн тасаг, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг, болон 13 сумаас иргэн, хуулийн этгээдэд Улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.

3.3.1.Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

Тайлангийн хугацаанд аймгийн хэмжээнд иргэний улсын бүртгэлээр нийт 51833 бүртгэл бүртгэж, иргэний улсын бүртгэлээр 12779 иргэнд лавлагаа олгосон байна. Үүнд:

- Төрсний бүртгэл-2341
- Эцэг тогтоолтын бүртгэл-72
- Гэрлэсний бүртгэл-82
- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-20
- Овог, эцэг/эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл-16
- Үрчилсний бүртгэл-6
- Нас барсны бүртгэл-154
- Гэрчилгээ дахин олголт-19
- Иргэний үнэмлэх бүртгэлээр-726
- Гадаад паспортын бүртгэл-1794
- Шилжилт хөдөлгөөний бүртгэл-138,
- Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл-32
- Лавлагаа-иргэнд:4044 албан хэрэгцээнд 1810

Иргэний улсын бүртгэлийн тухай хууль тогтоомж болон журамд заасан хугацаанд улсын бүртгэгч нарын бүртгэсэн иргэдийн бүртгэлийг онлайн системд хянан шалгаж баталгаажуулсан байна.

Тайлангийн хугацаанд Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia/-аар нийт 18 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгүүлэх хүсэлт, гаргасныг хянан шалгаж, 11 иргэний бүртгэлийг баталгаажуулж 7 бүртгэлийг хаяг буруу оруулсан, өмчлөгч биш шалтгаанаар татгалзсан.

3.3.2 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Иргэн, хуулийн этгээдээс нийт 2249 мэдүүлгийг хурууны хээгээр хүлээн авч, шийдвэрлэсэн байна. Үүнээс сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэх ажлын хүрээнд Мөнххаан, Эрдэнэцагаан сумдын улсын бүртгэгч нараар дамжуулан зэргэлдээ 6 сумдын иргэдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэн, 244 мэдүүлэг хүлээн авч шийдвэрлээд байна.

- ✓ Анхны бүртгэл нийт - 275, үүнээс газраас бусад үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 150, газар өмчлөх эрхийн анхны бүртгэл 125
- ✓ Өмчлөх эрх шилжих гэрээний бүртгэл - 474
- ✓ Барьцааны гэрээ болон бусад гэрээ – 1380
- ✓ Бүртгэлд өөрчлөлт оруулах – 78 бүртгэлийг тус тус хөтөлсөн байна.

Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр болон хууль хяналтын байгууллагад нийт 94 лавлагаа, мэдээллийг хууль, журмын дагуу олгоод байна.

Монгол улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 11 дугаар тогтоолын хавсралтаар “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам” батлагдаж Хүүхдийн мөнгө олгох өрхийг тодорхойлох босго шугамыг шинэчлэн тогтоосноор Эд хөрөнгийн өмчлөх эрхтэй холбоотойгоор иргэдээс өргөдөл гомдол олноор ирэх болсон. Энэ асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх ажлыг зохион байгуулж Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу хяналтын улсын байцаагчтай хамтран эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл

хөтөлсөн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийснээр улсын байцаагчийн 44 дүгнэлт гаргуулан зөрчлийг арилгах, цахим мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулах, дархардсан бүртгэлийг хаах зэрэг ажлыг цаг тухайд нь шийдвэрлэн ажилласнаар хүүхдийн мөнгөн тэтгэмжээ авах нөхцөл бололцоог бүрдүүлж, иргэдэд ээлтэй нээлттэй үйлчилж ажиллалаа.

ЭХЭУБГ-аас ирүүлсэн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллах хүрээнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд эд хөрөнгийн талбайн хэмжээ алдаатай 17, хөрөнгийн цахимжуулалтын болон хаагдсан бүртгэлийн өмчлөгчийн төлөв алдаатай 26, цахим мэдээллийн санд нэгж талбарын дугаарыг оруулаагүй 9, газрын зориулалтыг оруулаагүй, эсвэл зөрүүтэй оруулсан 278 бүртгэл нийт жагсаалтаар ирүүлсэн 330 бүртгэлд хяналтын улсын байцаагчийн 1500 тоот дүгнэлт болон эх нотлох баримтад үндэслэн холбогдох засвар өөрчлөлтийг хийсэн.

Хэлтсийн даргын А/14 тоот тушаалаар байгуулагдсан “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг тооллох комисс”-ын бүрэлдэхүүнтэйгээр архивын 15617 хувийн хэрэгт тооллого хийж, цахим сантай тулган, гарсан алдаа зөрчлийг тухай бүр нь залруулан ажиллалаа.

3.3.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

2023 оны эхний хагас жилийн байдлаар иргэн, хуулийн этгээдээс нийт 274 өргөдөл хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн.

Шинээр бүртгэсэн 64

Мэдээлэлд оруулсан өөрчлөлт 129

Салбар төлөөлөгчийн газар 3

Салбар төлөөлөгчийн газрын өөрчлөлт -12

Шилжин ирсэн хуулийн этгээдийн 9, Шилжин явсан хуулийн этгээдийн 2 бүртгэлийг хөтөлж хувийн хэргийг зохих журмын архивт шилжүүлсэн.

Төрийн бус байгуулагуудын 2022 оны үйл ажиллагааны тайлангаа 02 сарын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэхээр хуулийн хүрээнд сумын бүртгэгч нартай хамтран 70 хуулийн этгээдийн үйл ажиллагааны тайланг хүлээн авч архивлан хүлээлгэн өгсөн.

Хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад тамга, тэмдгийн хяналтын дугаар шинээр 64, дахин 22-ыг олгож, 24 хуулийн этгээдээс тамга тэмдгийг хураан авч архивчд хүлээлгэн өгсөн.

Иргэн хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтээр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 59 лавлагаа олгосон байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, баримт бичгийн олголтыг 301 иргэнд хийсэн байна.

3.6 Хяналт шалгалтын ажлын хүрээнд:

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлын мөрөөр хяналт шалгалт хийн, хяналтын улсын байцаагч зөрчил шалган шийдвэрлэхээр нийт 51 дүгнэлт гарган зөрчлийг шийдвэрлэсэн.

Зөрчлийн тухай хуулийн 15.24.1 дэх хэсгийг үндэслэн иргэний үнэмлэхний 25, 45 насны хугацаа сунгалтын бүртгэлээ хуулийн хугацаанд бүртгүүлээгүй болон Зөрчлийн тухай хуулийн 15.24.4 дэх заалтыг үндэслэн иргэний үнэмлэх хаяж гээсэн, гэмтээсэн 141 иргэн, 2 хуулийн этгээдэд 4450000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулж хялбаршуулсан журмаар зөрчлийг шалган шийдвэрлэж, орлогыг улсын төсөвт төвлөрүүлэн ажилласан байна.

2023 оны 05 дугаар сарын 5-наас 05 дугаар сарын 05-ны хооронд Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх удирдамж батлан, хяналт шалгалтын үйл ажиллагааг хийж байна.

Удирдамжийн дагуу Иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлээр улсын бүртгэгч нарын бүртгэсэн 310 бүртгэлд дотоод хяналт шалгалт хийсэн.

3.7 Архивын ажлын чиглэлээр:

Мөн байгууллагын ажлын байр нүүсэнтэй холбогдуулан архивыг нүүлгэн шилжүүлэх, хувийн хэргийг архивт байршуулах ажлыг хэлтсийн дарга болон хяналтын улсын байцаагчийн удирдлага, хяналт дор дотоод нөөцөө дайчлан зохион байгуулж, хэвийн ажиллагаанд оруулан ажиллаж байна.

УБЕГ-аас нягтаршуулсан шүүгээ 6 нэмж авч газраар хураалгатай байсан хувийн хэргүүдийг байршуулсан нь аюулгүй байдал болон архивын стандартын шаардлагад нийцсэн ажил болсон.



Иргэний улсын бүртгэлийн тасгийн 2022 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримт, хэргийн 23 боть, тоон гарын үсэг олгосон баримтын 3 боть, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт 2 боть нийт 27 боть эх материалыг архивт тушаав.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/290 тушаалын хавсралтын Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг архивт хадгалах журмын 4.5.1-нд заасны дагуу аймаг, дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэст бүртгэгдсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг болон улсын бүртгэлд бүртгэгдсэн эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг бүртгэл хийснээс хойш ажлын 1 өдөр, анхны бүртгэлийг ажлын 5 хоногийн дотор гэсэн журмыг үндэслэн улсын бүртгэгч нараас мэдүүлэг, нотлох баримт, анхны бүртгэлийг архивт хүлээн авч ажиллалаа.

3.8 Иргэдийг бичиг баримтжуулах, бичиг баримтын зөрчил арилгах ажлын хүрээнд:

БНХАУлсын Улиастай хотоор хиллэдэг Эрдэнэцагаан суманд хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэй 2 хоног ажилласан. Ажиллах хугацаандаа гадаад паспорт 207 ширхэгийн захиалга авч, 2 дүгнэлт гаргаж, 17 иргэний үнэмлэхний бүртгэл хийж иргэдийн бичиг баримтны зөрчлийг арилгалаа.



2023 оны 05 дугаар сарын 15-ны “Дэлхийн гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан Хилийн 0146 дугаар цэргийн ангитай хамтарч тус байгууллагын 4 хосын гэрлэлтийг ёслолтой бүртгэж байгууллагаа сурталчлан ажиллалаа.



Иргэдээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийн дагуу бүртгэлийн зөрчилтэй 12 иргэний ХААТР-11, 12, 13, 14, 15, 16, 18 маягтыг Улсын бүртгэлийн нэгдсэн архив болон хэлтсийн архиваас шүүж, зөрчлийг арилгасан.

Төрсний бүртгэл нь алдаатай төлөвтэй, төрсний бүртгэлд эцэг эхийн мэдээлэл дутуу, төрсний бүртгэлд ургийн овог нь буруу орсон, эцэг тогтоосний, үрчилсэний бүртгэлтэй боловч хүүхдийн ургийн овог нь эхийн ургийн овгоор мэдээллийн санд тусгагдсан болон мэдээллийн нэгдсэн санд бүртгэлийн төлөв нь буруу орсон 111 иргэнээс өргөдлийг хүлээн авч Иргэний улсын бүртгэлийн газарт хавсралтаар хүргүүлэн мэдээллийн санд засвар өөрчлөлт хийлгэн тус тус зөрчлийг арилгалаа.

УБЕГ-аас 2022 оны 11 дүгээр сард ирүүлсэн чиглэлийн дагуу засвар өөрчлөлтийн бүртгэлийн зарим төрлийг дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч бүртгэж эхэлсэн. Тайлангийн хугацаанд 45 иргэний засвар өөрчлөлтийн бүртгэлийг мэдээллийн санд тусгасан байна.

ДӨРӨВ. СУРГАЛТ

4.1. УБЕГ болон ЗДТГ, бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад албан хаагчдыг хамруулсан байдал:

- 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр АНУ-ын Дипломат аюулгүй байдлын албанаас УБЕГ-тай хамтран зохион байгуулсан цахим сургалтад 3 албан хаагч;
- 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан “Цахим гадаад паспортын бүртгэлийн программын танилцуулах” цахим сургалтад 10 албан хаагч;
- 2023 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Цахим гадаад паспорт хэрэглээнд нэвтүүлэхтэй холбоотой программын дадлага олгох” танхим, онлайн сургалтад 2 албан хаагч;
- 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагч” сэдэвт цахим сургалтад 2 албан хаагч,

- 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Амьдрах урлаг ба йога бясалгал” сэдэвт цахим сургалтад хэлтсийн 2 албан хаагч;
- 2023 оны 04 дүгээр сарын 24-нийн өдөр Улсын бүртгэлийн газрын Иргэний улсын бүртгэлийн газар, хяналт шалгалтын газраас хамтран зохион байгуулсан “Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл хөтлөх талаар” цахим сургалтад Улсын ахлах бүртгэгч Сайнбаяр,
- Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг танилцуулах хэлэлцүүлэгт 3 албан хаагч цахимаар хамрагдсан.

Тайлант хугацаанд 9 сургалтад хаагч нар хамрагдсан байна.

ТАВ. НЭГЖИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЛААР

УБЕГ-ын эрхэм зорилго, мэдээлэл, “Авлигагүй хамт олон”, Авлига, хүнд сурталгүй, ил тод байдлыг эрхэмлэн ажиллах уриатай самбар, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, захидал харилцаа, албан бичиг хэрэг, үйлчилгээний нийт албан хаагчдын эцэг/эх/-ийн нэр, нэр, албан тушаал, холбоо барих утасны дугаар, цагийн хуваарь, иргэд хүлээн авах цаг, холбоо барих утасны дугаар, ажил үүргийн хуваарь, иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, бүртгэлийн хяналт шалгалт зэрэг мэдээллийн самбарыг үйлчилгээний танхимд байршуулан ажиллаж байна.

Иргэний улсын бүртгэлтэй холбоотой мэдээллийг 70518914 эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой мэдээллийг 70512673, 70512673 “Лавлах үйлчилгээний утас”-ыг тогтмол ажиллуулж, иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээ, мэдээлэл зөвлөмжийг өгч байна.

Мөн Улсын бүртгэлийн үйлчилгээний бүрдүүлэх жагсаалтын QR кодыг үйлчилгээний цонхонд бүрэн байрлуулж харилцагчдыг мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна.

“Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс” гэсэн цахим хуудас болон мэдээллийн самбарт цаг үеийн шинжтэй мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэн, иргэдэд ойлгомжтой байдлаар байрлуулсан.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын хэрэгжилтийн хүрээнд Улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой шинээр гарсан хууль тогтоомж, дүрэм журам, Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм журам болон бусад цаг үеийн шинжтэй мэдээ мэдээлэл, “Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс” гэсэн фейсбүүк хуудаснаа нийт 26 мэдээ мэдээлэл сурталчилгааг байршуулан, 250 гаруй иргэн хандаж үзсэн байна.

Цахим хуудсаар Улсын бүртгэлийн цахим үйлчилгээ болон төлбөрийн цахим системийн талаар олон нийтэд сурталчилан таниулах /E-Mongolia/ төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний талаар/ болон тоон гарын үсэг, үндэсний энгийн гадаад паспортын талаар 25 мэдээлэл оруулж сурталчиллаа.

2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр “Үндэсний энгийн цахим гадаад паспорт”-ыг танилцуулах өдөрлөгийг Хэлтсийн “нэг цонхны үйлчилгээ”-ний танхимд зохион байгуулж төлөөлөл болгон нээж 10 иргэнд цахим гадаад паспортыг гардуулан өглөө.



ЗУРГАА. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙДАЛ

Цагаан сар буюу хаврын тэргүүн сарын шинийн 1-3-ны бүх нийтийн амралтын өдрүүдэд хариуцлагатай жижүүрийн хуваарийн дагуу 3 албан хаагч цаг үеийн байдлын мэдээг ерөнхий жижүүрт мэдэгдэн хариуцлагатай жижүүрээр ажиллалаа.

Засаг даргын “Стратегийн команд штабын сургууль зохион байгуулах тухай” захирамжын дагуу Онцгой комиссоос зохион байгуулсан онцгой комиссын гишүүдийн 2 удаагийн хурал, 1 сургалтад хамрагдсан.

“Нийслэлийн хэмжээнд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх стратегийн команд-штабын сургуулийн бэлтгэл ажил”-ын төлөвлөгөө болон түр цугларах байранд ажиллах албан хаагчдын нэрсийг гарган хүргүүлсэн. Онцгой байдлын зөвлөмжийн биелэлтийг ханган ажиллалаа.

Аймгийн нэгдүгээр ээлжийн цэрэг татлага спорт хороон дээр 2023 оны 05 сарын 05, 06-ны өдөр зохион байгуулагдлаа. Улсын бүртгэлийн хэлтсээс иргэдэд “Тоон гарын үсэг” олгож, бичиг баримтын зөрчлийг арилгах анхаарал хандуулж ажиллаа. Үүнд: Тоон гарын үсэг 56 иргэнд олгон цахим иргэний үнэмлэхний лавлагаа 13 иргэнд олгож, 5 иргэний үнэмлэхний бүртгэл хийж ажилласан байна.



2023 оны 06 сарын 07-ны өдөр Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллаж, аюулгүйн талбайд цугларах дадлагыг 2023 оны 06 дугаар сарын 07 өдөр бүх албан хаагчид хийлээ.



ДОЛОО. ИДЭВХ САНААЧЛАГА, ШИНЭЛЭГ АЖЛЫН ТАЙЛАН

Тоон гарын үсэг олгох ажлын талаар:

“Цахим гарын үсгийн тухай хууль”-ийн хэрэгжилтийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газар Хаан банктай хамтран зохион байгуулж байгаа “Тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх” аяны хүрээнд Хаан банкны салбар, харилцагч байгууллагууд болон албан хаагчдад нийт 1522 тоон гарын үсэг олгосон байна.

Бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлах, төрийн үйлчилгээг иргэнд ойртуулах зорилгоор байгууллагаас болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан “Цахим гадаад паспорт олголтын нээлтийн үйл ажиллагаа”, Хуульчдын “Про боноөдөр-2023”, Хаан банктай

хамтарсан “Тоон гарын үсэг олгох аян” болон нээлттэй хаалганы өдөрлөгүүдэд идэвхитэй оролцлоо.



ТАНИЛЦСАН ХЭЛТСИЙН ДАРГА *Н.Бадрахцог* Н.БАДРАХЦОГ
ТАЙЛАН ГАРГАСАН: БИЧИГ ХЭРЭГ *Ч.Мөнхгэрэл* Ч.МӨНХГЭРЭЛ